

**ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2017 ОНЫ ТАЙЛАН**

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Даланзадгад сумын Засаг даргын захирамжийн хүрээнд байгууллагын “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр 2016 онд 11 чиглэлээр 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тайланг төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааны зорилтын хүрээнд багцлан гаргав.

**1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт зорилтын хүрээнд:**

Даланзадгад сумын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/31 дүгээр захирамжаар баталгаажуулан сумын төсөвт байгууллагуудад хүргүүлэн төсөвт байгууллагуудын 2017 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллага тус бүрээр гаргуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

**2. Авлигаас ангид байх удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:**

Байгууллагуудын нийт албан хаагчдын хурал, удирдах ажилтны зөвлөгөөн, хурал, багийн ИНХ, байгууллагын албан хаагчдын хурал дээр байгууллагуудын удирдлага иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах, үйлчилгээний шат дамжлагыг бууруулах санал санаачлага гаргах, авлигаас урьдчилан сэргийлэх мэдээлэл хийсэн.

Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, соён гэгээрүүлэх болон байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний мэдээллийг нээлттэй хүргэх, байгууллага болон хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт хамгаалалтын байдлыг сайжруулах чиглэлээр байгууллагын төсвөөс тодорхой зардлыг зарцуулан ажиллаж байна. Төсвийн шууд менежер, ажилтнуудтай хийх үр дүнгийн гэрээнд удирдлагын болон хувь хүний манлайллыг хэрэгжүүлэхтэй холбогдсон заалтыг оруулж өгсөн.

**3. Байгууллагын онцлогт тохирсон ёс зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлэх зорилтын хүрээнд:**

ЗДТГ болон төсвийн байгууллагууд албан хаагчдын гаргасан ёс зүйн зөрчлийг хянан шалгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг чанд сахиж мөрдүүлэх чиг үүрэг бүхий Ёс зүйн хороог байгууллага бүр ажиллуулж төрийн албан хаагчийн ёс зүй болон багшийн ёс зүйг албан хаагч бүрд танилцуулан гарын үсгээр баталгаажуулан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод оруулан ажилласан.

ЗДТГ-ын холбогдох албан хаагчид “Төрийн албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцдагыг өндөржүүлэх сургалт, сахилга хариуцлагын зөвлөгөөн”-д хамрагдав.



### **Сахилга хариуцлагын зөвлөгөөн**

11 дүгээр цэцэрлэг цэцэрлэгийн үйл ажиллагаа, удирдлага, багш ажилтны ёс зүйн талаар эцэг эхчүүдээс санал асуулгаар санал авч 162 эцэг эх, асран хамгаалагч буюу цэцэрлэгийн нийт эцэг эхчүүдийн 74% нь хамрагдсан. Судалгаанаас харахад цэцэрлэгийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай-93%, сэтгэл дундуур-7% байна. Багшийн ёс зүйн дүрмээр багш, ажилтанд сургалт зохион байгуулж, Багшийн ёс зүйн дүрэм, багшийн ёс зүй хаана их алдагдаж зөрчигдөж байгаа талаар багш ажилчдад хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлэгт нийт 20 багш ажилчид, НТБТ-ийн 3 сургагч багш оролцлоо. Эцэг эхчүүдээс багш нарын ёс зүй харилцаа, ур чадвар, манлайллын талаар санал асуулгыг 3 сард авч ажиллалаа.

2017-2018 хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан БМДИ, АБСУГ-ийн СӨБ хариуцсан мэргэжилтэн нартай хамтарсан багш нарын ур чадварыг дээшлүүлэх багш нарын бага хуралд “Багшийн ёс зүйн дүрэм бусад хууль тогтоомжоор тодорхойлогдох нь” сэдэвт сургалтын цэцэрлэгийн арга зүйч Ч.Дуламсүрэн хийж тус сургалтад 13 багш хамрагдсан.


23 дугаар цэцэрлэг 2017-2018 оны хичээлийн жилийн багш нарын бага хурал “Багшийн ёс зүй- ёс суртахууны харилцаа сэдэвт сургалтыг 2017 оны 8 дугаар сарын 24-26 өдрүүдэд зохион байгуулсан. 2017.10.18.өдөр Нийслэлийн боловсролын газрын ахлах мэргэжилтэн З.Болормаа “Ёс зүй, ёс суртахууны харилцаа тэдгээрийн ойлголт “ сургалтад эрхлэгч Н.Наранцэцэг хамрагдсан.

25 дугаар БСУГ-аас 1 удаа ёс зүй сургалтыг албан хаагчдад зохион байгуулсан.

8 дугаар цэцэрлэг Авлига, ёс зүйн талаар 2017 онд 6 удаа нийт 784 эцэг эхээс санал асуулга авсан бөгөөд авилгатай холбоотой гомдол ирээгүй.

**4. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, авлигын эрсдэл ба авлига гаргах боломжийг бууруулах зорилтын хүрээнд:**

ЗДТГ болон төсвийн байгууллагын 2017 онд ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрийн жагсаалтыг гарган АТГ-т хүргүүлсэн. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний холбогдох албан хаагчдаас 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг цаасан болон цахим хэлбэрээр гаргуулан авч, [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) цахим хуудаст бүртгүүлэн, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн нэгдсэн тайланг гаргаж хуулийн хугацаанд Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан АТГ-т хүргүүлэн, хариу дүгнэлтийг хүлээн авч томилсон /6 албан хаагч/. ЗДТГ болон төсөвт байгууллагууд Авлигын тухай хуулийг байгууллагууд цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.



**Даланзадгад сумын цахим хуудсанд 2017 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулсан.**

##### **5. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах зорилтын хүрээнд:**

Хууль зүйн сайдын баталсан тушаалын дагуу 2017 оны худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллаж 2017 онд орон нутгийн хөгжлийн сангаар 3, аймгийн Засаг даргаас эрх шилжин ирсэн 12 ажлын үнэлгээний хороо байгуулагдаж 14 ажлын тендер зарлагдаж tender.gov.mn цахим сайтад байршуулан 7 ажлыг гүйцэтгэн хүлээн авч, 7 ажил гүйцэтгэлийн шатанд, 1 ажил тендер шалгаруулалтын шатанд явж байна.





**Төлөвлөлт:** 511м урт 2м өргөн 1022м<sup>2</sup> явган хүний яам

**Байршил:** 6-р баг, Шинэ суурьшлын бүс, Канад хаусын урд хэсгээс 25-р цэцэрлэг хүртэл



**Төлөвлөлт:** Машины 8м өндөртэй 4 ширхэг багантай, явган хүний 4м өндөртэй 4 ширхэг багантай, 3 худагтай, 1 удирдлагын самбартай

**Байршил:** 3-р баг, Эрдэнийн гүн төвийн урд уулзвар





Энхийн хүслэн өрхийн ээмнэлэгийн засвар



ӨӨРӨӨ БУУЛГАГЧТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ АВТОМАШИН



#### **4 дүгээр сургуулийн спорт заал**

Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын мэдүүлэгийг тухай бүр бөглүүлэн ажилласан. Хөндлөнгийн төлөөлөл 14 ажилд иргэний төлөөлөл ажиллуулж, “Бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаан”-д үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй болох тайлбарыг гаргуулан авч ХАСХОМ-ын бүртгэлд хөтөлж байна.

#### **6.Захиргааны хариуцлагын тогтолцоог үр дүнтэй ашиглах зорилтын хүрээнд:**

Төрийн албан хаагч нарт хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар мэдэгдэж ЗДТГ 2017 онд сахилгын зөрчил гаргасан 3 албан хаагчид сануулах, цалингийн хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

#### **7. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж ажиллах зорилтын хүрээнд:**

ЗДТГ нь “Е-ОФФИС”-ийн программыг ашиглан цаг алдалгүй, орон зайнаас үл хамааран хоорондоо харилцан ажиллаж, албан хаагчийн талаарх мэдээллийн танилцуулгыг Төрийн албан хаагч бүр хэрэгжүүлэн “Төрийн үйлчилгээний карт” /Иргэдийг хүлээж авч байна, Сургалттай, Хуралтай, Гадуур ажилтай, Эрүүл мэндийн шалтгаантай, Чөлөөтэй, Амралттай/ гэсэн картыг бий болгож төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх үйлчилгээг иргэдэд ойртуулан ажиллаж байна. Төсвийн байгууллагууд шилэн дансны мэдээллийн самбарт иргэдэд ойлгомжтой байдлаар төсөв санхүүгийн хүснэгтийг схемчилэн тогтмол байршуулдаг. ЗДТГ нь байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэрийн жагсаалт, үйлчилгээ авахад шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг гарган мэдээллийн самбар болон байгууллагын цахим сайтад байршуулсан. Төсөвт байгууллагуудын 1-3 дугаар улирлын захирамжлалын баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.





Цэцэрлэгийн үйл ажиллагааны мэдээллийн самбар



Албан хаагчийн талаарх мэдээллийн танилцуулга

#### 8. Байгууллагын төсвийг төлөвлөгдсөн зардалд үр ашигтай зарцуулах зорилтын хүрээнд:

Хуульд заасны дагуу байгууллагын мэдээллийн самбар, шилэн данс, цахим хуудсанд төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Энэ хүрээнд ЗДТГ-ын болон төсөв байгууллагуудын 2017 оны батлагдсан төсөв, сар, улирлын орлого, зарлагын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан. 2016 оны гүйцэтгэлийн тайлан, 2017 оны сар бүрийн орлого, зарлагын мэдээг шилэн дансны самбарт байршуулан ажиллаж байна. 2017 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг гарган Санхүү төрийн сангийн хэлтэст тушааж баталгаажуулсан тайланг [Shilendans.gov.mn](http://Shilendans.gov.mn) сайтад байршуулан ажилласан.



Шилэн дансны мэдээллийн самбар

**9. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах зорилтын хүрээнд:**

Төрийн албан хаагчдад авлигаас ангид байх талаар мэдээллийг хийж, иргэдэд БИНХ-аар, сургууль, цэцэрлэг эцэг, эх нарт авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталах ажлыг зохион байгуулан, цэцэрлэгүүд эцэг, эхээс санал асуулга авч ажилласан. ЗДТГ-ын албан хаагчдын дунд Авлига ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, 8 дугаар цэцэрлэг авилга, хүнд суртал, ёс зүйн талаар мэдээлэл авах 70532080 утсыг ажиллуулж байна. Цэцэрлэгүүд авлигын талаар сургалтыг эцэг, эхчүүдийн дунд зохион байгуулан ажилласан. Үүнд:

11 дүгээр цэцэрлэг 2017-2018 хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан БМДИ, АБСУГ-ийн СӨБ хариуцсан мэргэжилтэн нартай хамтарсан багш нарын ур чадварыг дээшлүүлэх багш нарын бага хуралд “Багш нар авилгалаас ангид байх нь” сэдэвт сургалтын төвийн 2, 24 дүгээр цэцэрлэгүүдийн арга зүйч Цасчихэр, Үүрцайх нар хийж тус сургалтад 13 багш хамрагдаж, цэцэрлэгүүд багш ажилтан нарт Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албан хаагчын ёс зүй, Манлайлагч сургалт, Хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүй, Гэр бүлийн тухай хууль ба гэр бүл төлөвлөлт сэдвүүдээр, авилгатай тэмцэх хууль суртлах таниулах зорилгоор ажлын байран дээр сургалтыг зохион байгуулсан.





11 цэцэрлэг Багш ажилтан нарт авилгатай тэмцэх хууль сурталчлах таниулах зорилгоор ажлын байран дээр АТГ-ын Авлигатай гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн ахлах мөрдөн байцаагч Ч.Золбообаатар сургалтыг зохион байгуулж, сургалтад 20 багш ажилтан хамрагдсан.

2 дугаар цэцэрлэг 2017 оны 4 дүгээр сарыг хууль сурталчлах уламжлалт аяныг зохион байгуулж “Авлигын эсрэг хууль”, болон “ Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг багш ажилтнаар судлуулж, эцэг эхчүүдэд хуулийн талаар мэдээлэл өгөх зорилгоор мэдээллийн самбарт хуулийг тавьж байрлуулсанаас гадна, эцэг эхийн сурган хүмүүжүүлэх хичээл дээр мэдээлэн таниулав.

## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТАЛААР ТА ХЭР МЭДЭХ ВЭ? / ИНФОГРАФИК/

© 2014/11/17 2104 0


АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ



# ГЭЖ ЮУ ВЭ?


ТРАНСПЕРЕНСИ ИНТЕРНЕЙШНЛ БАЙГУУЛЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ:

**“Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь Төрийн албан хаагч төрийн ашиг сонирхолд болон улсын ашиг сонирхолд үйлчлэхээсээ илүү төрийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон эрх мэдлээ ашиглаж өөрийн үзэмжээр хувийн ашиг сонирхолдоо үйлчлэх нөхцөл байдлыг ойлгоно” гэжээ.**



Сургалтууд





5 Дугаар сургууль Авлигатай тэмцэх газрын цахим хуудснаа “Баадай болон түүний гэр бүл” сэдэвт хялбаршуулсан гарын авлагыг анги удирдсан багш нараар дамжуулан сурагчдад таниулан, сурталчилсан.

**10. Хяналт шинжилгээ орон тооны бус багийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах зорилтын хүрээнд:**

Аймгийн Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу сумын ЗДТГ-ын дэргэдэх Хяналт, шинжилгээ үнэлгээний Орон тооны бус баг нь сумын төсвийн 15 байгууллагад Хяналт шинжилгээ үнэлгээг 2016.1 сард хийж заавар, зөвлөгөөг өгч ажилласан.



**Хяналт, шинжилгээ үнэлгээний явцаас**

**11. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангаж ажиллах зорилтын хүрээнд:**

Байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” хөтөлбөр, “Төрийн албан хаагчийн сургалт” хөтөлбөрүүдийг боловсруулан, төлөвлөгөөг гарган сул орон тооны ажлын зарыг байгууллагын цахим сан болон мэдээллийн самбарт байршуулан ажилласан.

ХЯНАСАН:  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Э.МӨНХБОЛОР

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:  
ДОТООД АЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН В.ДЭЛГЭРМАА